



## Хямралын үед багш, боловсролын салбарын ажилтнуудыг дэмжих нь

### Оршил

2020 оны 4 дүгээр сарын дунд гэхэд КОВИД-19-ийн эсрэг хариу арга хэмжээний хүрээнд дэлхийн ихэнх улс орнууд сургууль болон боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг зогсоосон нь дэлхийн нийт сурагчдын 90 гаруй хувь болох 1,57 тэрбум суралцагчдад нөлөөлж байна. Эдгээр арга хэмжээ нь өвчний тархалтыг бууруулах, олон нийтийн эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай боловч боловсролын тогтолцооны бүх түвшинд дэлхий нийтийн суралцахуйн хямралыг бий болгож болзошгүй юм. Хямралын үеийн боловсролын хариу арга хэмжээ нь технологийн бус, бага болон өндөр технологийн олон төрлийн нөөц, арга хэрэгслийг ашиглан суралцахуйн тасралтгүй байдлыг хангах, сургалтын агуулгыг сургуулийн орчноос суралцагчдын гэрт хүргэхэд чиглэсэн болно.

Аливаа хямралын үед авч буй хариу арга хэмжээний чухал хэсэг нь боловсролын салбарын тэргүүн эгнээний ажиллах хүч болох багш, хичээлийн эрхлэгч, боловсролын салбарын ажилтнууд бөгөөд тэдгээрийн КОВИД-19-ийн эсрэг үзүүлж буй хүчин чармайлт, бүтээлч сэтгэлгээ нь зарим тохиолдолд үл анзаарагдах тохиолдол байдаг. Өнөөдрийн байдлаар цар тахал нь хамгийн багадаа 63 сая бага, дунд ангийн багш нарт нөлөөлж байна. Цаашилбал, үндсэн сургалтын тасалдал нь багш бэлтгэх байгууллагуудын суралцагчдад нөлөөлж, ирээдүйд мэргэшсэн багш нарын хомсдол дэлхий дахинд бий болох аюул заналхийлж байна.

Тиймээс ЮНЕСКО нь багш, хичээлийн эрхлэгч, боловсролын салбарын ажилтнуудыг хамгаалах, дэмжих, өнөөгийн эрүүл мэндийн хямралтай тэмцэх хариу арга хэмжээнд тэдний оруулж буй хүчин чармайлтыг хүлээн зөвшөөрөхийг уриалж байна.

## **Сэдэв болон холбогдох асуудлуудыг тодорхойлох**

КОВИД-19 цар тахлын үед дэлхийн өнцөг булан бүрд багш нарт заавар зөвлөмж, сургалт, дэмжлэг, нөөцийн хангалтгүйгээр суралцагчдыг зайн сургалтад дасан зохицоход нь туслахын тулд ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна. Ялангуяа орлого багатай улс орнуудад өнөөгийн хямралын үед алсын зайнаас заах боломжгүй гэрээт, цагийн багш зэрэг олон багш нар орлого болон ажлын байрны аюулгүй байдалтай холбоотой улам бүр нэмэгдэж буй асуудлуудтай нүүр тулсаар байна. Дэлхийн зарим улс оронд асран хүмүүжүүлэгч болон нийгмийн бүлгүүдтэй харилцах гол сувгуудыг нээлттэй байлгах, эмзэг бүлгийн хүүхдүүд, эрүүл мэндийн ажилтнууд зэрэг зайлшгүй шаардлагатай ажилчдын хүүхдүүдэд танхимын боловсрол олгохын тулд багш нарыг өөрийн биеэр сургууль дээр ажиллахыг шаардаж байгаа бөгөөд суралцахуйн үйл явцыг таслалдуулахгүйн тулд тэд өөрсдийн эрүүл мэндийг эрсдэлд оруулж байгаа юм.

Ирээдүйн багш нарт ч мөн хямрал нөлөөлж байна. Суралцагч багш нар нь сургуулийн үйл ажиллагаа зогссоноос болж сургалт нь цалгардаж буй суралцагчдын тоонд багтаж байгаа бөгөөд багшийн сургалтын байгууллагад биечлэн суралцах болон удирдлага дор байх бололцоогүй болсон төдийгүй танхимд багшлах зайлшгүй туршлага олж авахад саад учирч байна. Хямралаас өмнө ч дэлхий нийт мэргэшсэн, бэлтгэгдсэн багш нарын хомсдолтой тулгарч байсан бөгөөд 2030 он гэхэд бүх нийтийн бага, дунд боловсрол эзэмших эрэлт хэрэгцээг хангахын тулд 69 сая шинэ багш шаардлагатай байна. Одоогийн болон ирээдүйн багш нарын мэргэшил дээшлүүлэх хэрэгцээг КОВИД-19-ийн эсрэг хариу арга хэмжээний нэг хэсэг болгохгүй бол энэхүү цар тахлын богино болон урт хугацааны үр нөлөө нь чанартай боловсрол олгох, суралцахуйн үр дүнг сайжруулах багш нарын чадамжид ихээр нөлөөлөх болно.

Өнөөгийн хямралын үед суралцагчдын сайн сайхан байдал, хамгаалалт, аюулгүй байдлыг чухалчлахаас гадна засгийн газар болон бусад гол түншүүд нь Багш нарын төлөв байдлын тухай ОУХБ / ЮНЕСКО-ийн 1966 оны зөвлөмж, Дээд боловсролын сургахуйн боловсон хүчний төлөв байдлын тухай ЮНЕСКО-ийн 1997 оны зөвлөмжид тусгагдсны дагуу боловсролын салбарын ажилтнуудад халамж үзүүлэх үүрэгтэй байдаг.

ЮНЕСКО-ийн Багш нарын ажлын хэсэг нь сүүлд боловсруулагдсан Арга хэмжээ авах тухай уриалгадаа КОВИД-19-ийн үед засгийн газар болон бусад гол түншүүд нь ямар халамж үзүүлэх шаардлагатай талаар нарийвчлан тусгасан. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлт, цалин хөлсийг хадгалан үлдэх;
- Багш нарын болон суралцагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдлыг чухалчлах
- КОВИД-19-ийн эсрэг хариу арга хэмжээг боловсруулах үйл явцад багш нарыг татан оролцуулах
- Мэргэжлийн зохих дэмжлэг, сургалтаар хангах
- Тэгш боломжийг боловсролын хариу арга хэмжээний үндсэн зорилго болгох
- Тусламжийн хариу арга хэмжээнд багш нарыг оролцуулах зэрэг болно.

Хямралын эсрэг хариу арга хэмжээний үед болон цаашид ч сургуулиуд эргэн үйл ажиллагаагаа хэвийн явуулах хүртэл суралцахуйн тасалдалтын эсрэг арга хэмжээ болох зайн сургалтыг амжилттай явуулах үүднээс багшийн мэргэжлийн сүлжээг хөгжүүлэх, багш, суралцагч, тэдний гэр бүл, хамт олон хоорондын харилцааг тогтвортой байлгах арга замыг олох нь нэн чухал юм. Мөн цаашдын сорилт бэрхшээлд тэсвэртэй, хариу үйлдэл үзүүлэх чадвартай тэгш хамарсан, тэгш боломжит боловсролын тогтолцоог бий болгохын тулд багш, хичээлийн эрхлэгч зэрэг бүх оролцогч талууд хамтран ямар арга хэмжээ яагаад бүтэмжтэй хэрэгжсэн, хаана ямар дутагдал гаргасан, мөн тэдгээрийг хэрхэн шийдвэрлэж болох талаар эргэцүүлэн хянаж, судалж, системчилсэн үнэлгээ хийх шаардлагатай болно.

- **Багш нарын эрэлт хэрэгцээ, чадавх, боловсролын ханган нийлүүлэлтийн зөрүүгийн талаар найдвартай, нарийвчилсан мэдээлэл нь хямралын эсрэг үр дүнтэй арга хэмжээ авахад чухал үүрэг гүйцэтгэдэг.** Боловсролын салбарын ажиллах хүчний менежментэд хямралд мэдрэмжтэй хандлагыг бий болгох нь багш, ажилтнуудын талаарх иж бүрэн ойлголтыг бий болгохоос гадна боловсролын салбарт тулгамдаж буй дутагдал, хоцрогдлыг олж тогтоох явдал юм.

Ийм ойлголт нь засгийн газар болон бусад түншүүдэд тодорхой бүлгийн багш нарыг сонгон авч, чадавх, хэрэгцээнд нь тулгуурлан тэдний дэмжлэгийг илүү үр дүнтэй зохицуулах боломжийг олгодог төдийгүй баримтад тулгуурласан багшийн хуваарилалтаар дамжуулан багшийн ажиллах хүчний хомсдлыг шийдвэрлэх богино болон урт хугацааны төлөвлөгөөг боловсруулахад туслах юм. Харамсалтай нь дэлхийн олон оронд багш нарын талаарх баримт мэдээлэл хуваагдмал, найдвартай биш эсвэл бүр байхгүй байгаа нь КОВИД-19 цар тахлын үеэр онцлон тэмдэглэснээр хямралын эсрэг үр дүнтэй хариу арга хэмжээний стратеги боловсруулахад хүндрэл учруулж байна. Гэсэн хэдий ч өнөөгийн хямрал нь одоо авч буй арга хэмжээ болон боловсролын хөгжлийн цаашдын стратегийг мэдээлэхэд багш нарын талаарх цогц бөгөөд нарийвчилсан баримт мэдээллийг цуглуулж эхлэх боломжийг олгож байна.

- **Ажлын байрны аюулгүй байдал, цаг хугацааны зохих нөхөн олголтууд нь хямралын үед багшийн хүсэл эрмэлзлийг хадгалж, ажилд нь үлдээхэд тусалдаг.** Багш нарт цаг тухайд нь өндөр цалин хөлс олгодог боловсролын тогтолцоо нь ажлын сэтгэл ханамж, ёс суртахууны түвшин өндөр байдаг мэргэшсэн багш нарыг ажилд авах, ажилд нь үлдээх боломжтой. Хямралын үед багш нарыг багшлах ажлаа хүсэл эрмэлзэлтэйгээр хийхэд нь, ялангуяа тэдний ихэнх өөрсдийн сайн сайхан байдлыг эрсдэлд оруулан бусдын хүүхдэд боловсрол олгодог тул багш нарт цаг тухайд нь, цалин хөлсийг нь бүтнээр олгох нь чухал юм. Уганда, Филиппин зэрэг зарим улс орнууд өнөөгийн хямралын үед зохих ёсоор, цаг тухайд нь нөхөн олголтууд олгох нь чухал гэдгийг хүлээн зөвшөөрч цалинг хугацаанаас өмнө олгох, аюулгүй байдлын урамшуулал, хувцсаар хангах зэрэг зохицуулалтыг багш нарт зориулан хэрэгжүүлж байна. Түүнчлэн, нэн ялангуяа боловсролын тогтолцооны доод түвшинд эмэгтэй хүмүүс ихэвчлэн багшилдаг, мөн охидыг сургуульд эргэн ороход эмэгтэй багш нарын оролцоо чухал үүрэг гүйцэтгэдэг учир тэднийг хэрхэн авч үлдэх талаар онцгой анхаарах хэрэгтэй. Боловсролын салбарын зардлын ихэнх хувийг багш нарын цалин эзэлдэг тул хямралын үед улс орнууд шаардлагатай санхүүгийн нөөцийг дайчлах боломжгүй байна. Багшийн цалин хөгжлийн тусламжид ихэвчлэн багтдаггүй тул хямралын үед Дэлхийн банкнаас эрүүл мэндийн ажилтнуудад дэмжлэг үзүүлсний адил багш нарт нөхөн олговор олгох, ажил хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангахад олон улсын туслалцаа авах шаардлага байж магадгүй юм.
- **Хямралын үед багш нар зохих, чанартай мэргэжлийн хөгжил, дэмжлэг авах хэрэгтэй.** Багш, боловсролын салбарын ажилтнууд хямралын үед сургалтаа үргэлжлүүлэх боломжтой байхын тулд зохих, чанартай мэргэжлийн хөгжил, дэмжлэг авах хэрэгтэй. Сургуулийн үйл ажиллагаа зогссон энэ үед Боловсролын нээлттэй эх сурвалж, Олон нийтийн нээлттэй онлайн сургалт, интернэтийн холболтын асуудалтай үед олон нийтийн телевиз, радио зэрэг зайн сургалтын олон аргаар дамжуулан мэргэжлийн хөгжил болон дэмжлэгийг хүргэж байна. Энэхүү үед сурган хүмүүжүүлэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор ЮНЕСКО нь багш нарт өөрийн дижитал агуулгыг бий болгоход зориулж олон тооны эх сурвалжийг цуглуулж, ЮНЕСКО-ийн Африк дахь чадавх бэхжүүлэх олон улсын хүрээлэн нь багш нарт зориулж виртуал кампусыг нээв. Олон нийтийн нээлттэй онлайн сургалтуудыг багш нарын туршлага дээр суурилсан мэдлэг, сайн туршлагыг бий болгох, түгээх платформоор хангах замаар багш нарыг хямралд нэрвэгдсэн бүлгээс сурган хүмүүжүүлэгч болгон хувиргахад ашиглаж болно.

- КОВИД-19 хямрал нь багшилж буй, мөн суралцаж буй багшийн боловсролд шинэчлэл зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.** Хямралын үед онлайн сургалтын хөтөлбөрөөс авсан сургамжаас харахад сургалтын үр ашгийг бүрэн дүүрэн ойлгохын тулд багш нар хэрэглэж буй технологио сайтар ойлгож, бүрэн эзэмшсэн байх хэрэгтэй. Харамсалтай нь зохих дэд бүтэц, холболтын таатай нөхцөлд ч ихэнх сурган хүмүүжүүлэгч багш нар МХХТ-ийн анхан шатны мэдлэг чадваргүй байгаа нь зайн сургалтыг чанартай явуулах нь бүү хэл, өөрсдийн мэргэжлийн хөгжилд саад бэрхшээлтэй нүүр тулгарч байна. Ерөнхийдөө, сурган хүмүүжүүлэгчдийн болон сургуулийн цахим бэлэн байдлын талаарх ойлголтыг бий болгох, үйлдвэрлэлийн дараах, мэдлэгт суурилсан дэлхийн нийгмийн хэрэгцээг хангахын тулд багшийн боловсролыг сургалтын хөтөлбөрийн болон сурган хүмүүжүүлэх инновацаар дамжуулан шинэчлэх шаардлагатай. Зайн сургалт нь багш нарыг орлож чадахгүй боловч багш нарт суралцагч төвтэй практикийг хөгжүүлэх, сургалтын хөтөлбөрийн олон төрлийг нэмэгдүүлэх, ганцаарчилсан сургалтыг илүү сайжруулахын тулд МХХТ, дижитал суурь боловсрол, мэдээллийн үнэлгээ хийх чадварыг хөгжүүлэхэд нь түлхэц болох багшийн боловсролын томоохон шинэчлэл хийх шаардлагатай байгааг энэ хямрал харуулж байна.
- Хямралын өмнөх, дараа болон энэ үед багш нарын сайн сайхан байдал, нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн үр чадвар, тогтвортой байдлыг дэмжих нь чухал юм.** Хямралын үед багш нарын талаар хийж буй судалгаа нь тэдний нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн үр чадвар, тогтвортой байдлыг бий болгохын ач холбогдлыг харуулж байна. Өөрийн сэтгэлзүй, нийгмийн харилцааны үр чадвараа хөгжүүлсэн, мэргэжлийн тайлагнах болон зөвлөх үйлчилгээний дотоод сургалтын хичээлүүдэд хамрагдах боломжтой багш нарын сурагчиддаа сэтгэлзүй, нийгмийн дэмжлэг үзүүлэх, тэдэнд энэхүү хямралын үед тулгарч буй тодорхой бус байдал, түгшүүрийг даван туулахад нь туслах чадвар илүү хөгжсөн байдаг. Илүү тогтвортой нөхцөл байдалд ч нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн үр чадварыг эзэмшээгүй, түршлага багатай, залуу багш нар стресс, ядаргаанд орж улмаар шалтгаангүйгээр ажил таслах, ажлаас гарах, багшлах чанар муудахад хүргэдэг. Ирээдүйд эдгээр нийгмийн харилцааны болон сэтгэл хөдлөлийн үр чадваруудыг багшийн боловсролд тусгаж өгөх шаардлагатай байна.
- Багш нарын санаачилга, практик бүлгүүдийг дэмжих нь хямралын эсрэг үр дүнтэй хариу арга хэмжээ авахад тусална.** Дэлхий даяарх багш нар заах арга барилаа сайжруулахын тулд мэргэжил нэгт нөхөдтэйгээ хамтарч ажиллах, мэргэжлийн харилцаа холбоо чухал болохыг онцоллоо. Өнөөгийн цар тахлын улмаас багш нар хоорондоо биечлэн уулзаж үйл ажиллагаа явуулахад бэрхшээлтэй байгаа ч гар утсаар зөвлөх, давтлага өгөх зэрэг олон төрлийн виртуал замаар холбогдон мэргэжлийн болон нийгмийн сэтгэлзүйн дэмжлэгээр бие биенээ дэмжиж буй жишээнүүд байна. Зарим засгийн газрууд хямралын үед багш нарын санаачилгыг дэмжих нь чухал гэдгийг онцолсон бөгөөд Коста-Рика, Хорват, Филиппин зэрэг улс багш нарт дэмжлэг үзүүлэх, сургалтын агуулгад илүү хариуцлагатай хандах үүрэг өгөхийн тулд виртуал платформ ашиглаж байна. Боловсрол Интернэшнл, Багш нарын ажлын хэсэг зэрэг олон улсын байгууллага болон багш нарын үндэсний байгууллагуудын дэмжлэгтэйгээр засгийн газар болон түншүүд нь багш нарын мэргэжлийн сүлжээг бэхжүүлэхэд анхааран ажиллаж байна. Боловсрол Интернэшнл нь Хямралын эсрэг дэлхийн эв нэгдэл, хүн төвтэй хандлагын уриалгыг, Багшийн ажлын хэсэг нь цар тахлын эсрэг Арга хэмжээ авах тухай уриалгыг тус тус боловсруулаад байна.
- Багш, сурагчдын хоорондын харилцааг тогтвортой байлгахад КОВИД-19-ийн эсрэг хариу арга хэмжээнд хүн төвтэй хандлага зайлшгүй шаардлагатай.** Өнөөгийн хямралаас шалтгаалан боловсролын хүртээмж, чанар, тэгш боломжид тулгарч буй хамгийн том бэрхшээл бол хоорондын зай барих явдал бөгөөд энэ нь багш нар суралцагчидтай, ялангуяа хамгийн эмзэг бүлгийн суралцагчидтай ойр харилцаа холбоогоо хадгалж үлдэхэд бэрхшээл учруулдаг. Итали, Коста Рика, Иран, Уганда зэрэг олон орон багш, сурагч, асран хамгаалагчдын хоорондох сүлжээг бий болгох, тогтвортой байлгахын тулд WhatsApp болон бусад олон нийтийн мэдээллийн

хэрэгсэл, мессежийг ашиглаж байна. Хямралын эсрэг хүн төвтэй арга хэмжээ авах нь урт болон богино хугацаанд чухал бөгөөд урт хугацааны хувьд сургуулиудын үйл ажиллагааг дахин хэзээ, хэрхэн хэвийн болгох талаар шийдвэр гаргах үед багш, сурагч, гэр бүлд учрах эрсдэл болон давуу талыг үнэлж, тэнцвэржүүлэхэд чухал юм.

## **Бодлого, хөтөлбөр зохицуулалтыг төлөвлөхтэй холбоотой гол санаа, практик зөвлөмж**

### **КОВИД-19-ийн эсрэг хариу арга хэмжээг үргэлжлүүлэх цогц зарчим, удирдамж**

1. Боловсролын тэгш хамарсан тогтолцоо нь нэн ялангуяа эмзэг бүлгийн бүх суралцагч, багш нарын хэрэгцээ, эрхийг харгалзан үзэх ёстой. Багш, боловсролын салбарын ажилтнууд нь зөвхөн үйлчилгээ үзүүлэгчид байгаад зогсохгүй, тэд бол эрх эдлэгчид бөгөөд боловсролын эерэг шинэчлэлийн хүчтэй хүчин зүйл учраас КОВИД-19 хямралын эсрэг хариу арга хэмжээг төлөвлөхөд оролцох ёстой.
2. Хүмүүнлэгийн хариу арга хэмжээ авах эхний зарчим бол ямар ч хор хохирол учруулахгүй байх явдал юм. Өнөөгийн хямралын үед улс орнууд үүнийг хэрэгжүүлэхийн өмнө тухайн багш, сурагчдын аюулгүй байдал, эрүүл мэнд, сэтгэцийн болон сэтгэл санааны сайн сайхан байдал, боловсрол, амьжиргаанд учирч болзошгүй эрсдэлийг анхааралтай авч үзэх хэрэгтэй. Энэ зарчим нь сургуулиудын үйл ажиллагааг хэзээ, хэрхэн хэвийн болгох тухай шийдвэрт хамаарна.
3. Дэлхий даяар ажиллаж буй мянга мянган боловсролын оролцогч талуудын туршлага дээр үндэслэн боловсруулсан Онцгой байдлын үе дэх боловсролын агентлаг хоорондын сүлжээний (ОБУБАС) Боловсролын хамгийн доод стандарт нь хямралын үед болон түүнээс хойшх хугацаанд боловсролд хэрхэн арга хэмжээ авах тухай ач холбогдолтой удирдамж юм. Тодруулбал, ОБУБАС-ий хамгийн доод стандартууд нь Багш, боловсролын салбарын бусад ажилтнуудад болон Заах, суралцахуйн тухай удирдамжаар хангахаас гадна хямралын үед болон хойшх хугацаанд суралцагч, сургагч, хамт олны оролцоо, эрүүл мэнд, аюулгүй байдал болон сайн сайхан байдлыг хангах талаар зааварчилгаа өгдөг.

### **Багшийн хэрэгцээ, чадавх, хангамжийн дутагдлын талаар мэдээлэл цуглуулах практик зөвлөмж**

- Богино хугацаанд
  - ✓ Багш нарын чадавх, тэдгээрийн мэргэжлийн, санхүүгийн болон нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөлийн хэрэгцээг тодорхойлох, баримтжуулах.
  - ✓ Сургуулиудын үйл ажиллагаа дахин хэвийн болох үед боловсролын хангамжийн болон сургалтын дутагдал хаана байгааг тодорхойлж, баримтжуулах.
  - ✓ Боломжтой нөхцөлд, багш нарт цар тахлын үзүүлж буй сөрөг үр нөлөөг илүү ойлгох, шийдвэрлэхийн тулд багш нарын мэдээллийг жендэр, байршил болон бусад үзүүлэлтээр нь нарийвчлан задлах.
- Дунд болон урт хугацаанд
  - ✓ Бодлого боловсруулагч, төлөвлөгч, хэрэгжүүлэгч нар нь ирээдүйн хямралын эсрэг хариу арга хэмжээ авахдаа мэдээлэлд суурилсан шийдвэр гаргахад илүү туршлагатай байхын тулд Багшийн удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлэх / засварлах замаар багш нарын талаарх нарийвчилсан мэдээллийг цуглуулах ажлыг системчлэх.

### **Нөхөн олговор болон ажлын байрны аюулгүй байдлын талаарх практик зөвлөмж**

- Богино хугацаанд
  - ✓ Эрүүл мэнд, хүүхэд асрах шаардлага, эсвэл интернэт холболт зэргээс шалтгаалан ажиллах боломжгүй багш болон бүх багш нарын цалин, тэтгэмжийг цаг тухайд нь олгох.
  - ✓ Шаардлагатай ажилчдын хүүхдүүдэд болон техникийн бололцоогүй гэрт биечлэн очиж зааж буй багш нарт ажлын аюултай орчны нэмэлт төлбөр олгох, хүүхэд асрах үүрэг хүлээсэн багш нарт нэмэлт дэмжлэг хэрхэн үзүүлэх талаар анхаарч үзэх.
  - ✓ Сургуулийн үйл ажиллагаа зогссон үед сургалтын хангамжийг дэмжих ажилд дайчлагдаж болох гэрээт багш, цагийн багш нарыг тодорхойлж тэдэнтэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах.
- Дунд болон урт хугацаанд
  - ✓ Боловсролын салбарыг, түүний дотор багшлах боловсон хүчнийг тогтвортой санхүүжүүлэх талаар судалж, ухуулга явуулах.

### **Нөхөн олговор болон ажлын байрны аюулгүй байдлын талаарх практик зөвлөмж**

- Богино хугацаанд
  - ✓ Боломжтой тохиолдолд холбогдох эх сурвалж, дэмжлэгийг хуваалцах албан ёсны платформыг бий болгох.
  - ✓ Хямралын үед сургалтын хөтөлбөр, зайлшгүй хичээлүүд, сургалтын үнэлгээний талаарх удирдамжийг сонгох, боловсруулах, түгээх, мөн КОВИД-19 хямралын дараагаар сургуулиудын үйл ажиллагаа нэн даруй хэвийн болох үед бэлтгэж багш нарыг түргэвчилсэн / засварлах шаардлагатай боловсролын арга барилд сургахын тулд багшийн боловсролын институтууд болон багш нарт зориулсан байгууллагуудтай хамтарч ажиллах.
  - ✓ Сургуулиудын үйл ажиллагаа зогссон үед захирал, багш болон боловсролын салбарын бусад ажилтнуудыг сурагчдыг нэн шаардлагатай мэдээллээр зайнаас хэрхэн хангах талаар холбогдох удирдамжаар хангах.
- Дунд болон урт хугацаанд
  - ✓ КОВИД-19-ийн цаашдын дэгдэлтийн эрсдэл, урьдчилан сэргийлэх үндсэн арга хэмжээний талаар захирал, багш, боловсролын салбарын бусад ажилтнуудын мэдлэг, мэдээлэлтэй байдлыг хангах.
  - ✓ Сурган хүмүүжүүлэхэд МХХТ-ийг хэрэглэх чадварыг хөгжүүлэх, зайнаас боловсрол олгох тухай бэлтгэл сургалт явуулах зэрэг анхан шатны багшийн боловсролын шинэчлэлд хөрөнгө оруулахаас гадна онцгой байдал, зэвсэгт мөргөлдөөн, гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн боловсрол олгох чиглэлээр хөрөнгө оруулалт хийх.
  - ✓ Шинэ технологид дасан зохицох, мөн хямралаас урьдчилан сэргийлэх, бэлтгэх, хариу арга хэмжээ авах чадварыг дээшлүүлэх зэрэгт бэлтгэгдэж буй багш нарын боловсролын шинэчлэлд хөрөнгө оруулалт хийх.

### **Багш, боловсролын салбарын бусад ажилтнуудад сэтгэлзүй, нийгмийн тусламж үзүүлэх практик зөвлөмж**

- Богино хугацаанд
  - ✓ Хямралын үед багш, боловсролын салбарын бусад ажилтнуудад нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөлийн ур чадвараа хөгжүүлэхэд нь туслах нөөц боломжоор хангах.
  - ✓ Багш нараас зөвлөгөө авах, хүүхдийг хамгаалах асуудлаар ярилцах боломжийг олгох тусламжийн утас эсвэл бусад механизмыг бий болгох.
- Дунд болон урт хугацаанд

- ✓ Нийгмийн харилцаа, сэтгэл хөдлөлийн чадамжийг бэлтгэгдэж буй багшийн боловсрол, түүнчлэн албан ёсны мэргэжлийн хөгжилд хамруулахад анхаарах.
- ✓ Төрийн захиргаа болон сургууль зэрэг олон түвшинд багш нарт болон боловсролын салбарын бусад ажилтнуудад зөвлөлдөх, зөвлөгөө авах боломжийг олгох албан ёсны нэгж /механизмыг бий болгох.

### **Багш нарын мэргэжлийн харилцааг дэмжих, хямралын эсрэг хариу арга хэмжээнд тэднийг оролцуулах тухай практик зөвлөмж**

- Богино хугацаанд
  - ✓ Хямралын эсрэг хариу арга хэмжээ, нэн ялангуяа зайн боловсролыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянахтай холбоотой шийдвэр гаргалт, сургуулиудын үйл ажиллагааг хэвийн болгох төлөвлөлт, бодлогын хэлэлцүүлэгт багш нарын дуу хоолой, хэрэгцээг оруулах талаар олон улсын, бүс нутгийн, үндэсний багш нарын байгууллагууд, түүнчлэн төвлөрсөн бус түвшний боловсролын удирдагчидтай зөвлөлдөх. Шийдвэр гаргах үйл явцад эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн тэгш төлөөллийг хангах, цөөнх болон алслагдсан хүмүүсийн дуу хоолойг хэлэлцүүлэгт оруулахад онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.
  - ✓ Сургуулийн үйл ажиллагаа зогссон үед удирдлага, мэргэжлийн үр чадвар, дэмжлэгийн тасралтгүй байдлыг хэрхэн хангах талаар багшийн боловсролын байгууллагатай зөвлөлдөх.
  - ✓ Виртуал платформд нэвтрэх эсвэл олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан багш нарын (сургалтын байгууллага дотор болон хооронд) хоорондын харилцаанд дэмжлэг үзүүлэх.
- Дунд болон урт хугацаанд
  - ✓ Багш нарын хоорондын практик болон бусад мэргэжлийн харилцааг хүний, институцийн болон санхүүгийн хөрөнгө оруулалтаар урт хугацаанд тогтвортой байлгах.
  - ✓ Багшийн бодлого, практикийн шинэ мэдлэгийг тасралтгүй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор сургуулийн удирдлага, багш, сурган хүмүүжүүлэгч, судлаач, бодлого боловсруулагч нарыг хамруулан сэдэвчилсэн сургалтын нийгэмлэгүүдийг бий болгох.
  - ✓ Цаашдын хямралын бэлэн байдлыг хэрхэн сайн хангах, юу төлөвлөгөөний дагуу явагдсан, юу явагдаагүй гэдэг дээр үндэслэж хөндлөнгийн оролцооноос авсан сургамжийг үнэлэх, баримтжуулах (багшийн судалгаа мөн орно)

### **Багш нарын мэргэжлийн харилцааг дэмжих, хямралын эсрэг хариу арга хэмжээнд тэднийг оролцуулах тухай практик зөвлөмж**

- Богино хугацаанд
  - ✓ Хямралын үеийн харилцаа холбоог зохицуулах ажилтныг томилох, сургуулийн ажилтнууд, суралцагчид болон тэдний ар гэр хоорондын харилцааг дэмжих, хямралын эсрэг хариу арга хэмжээний талаар сургуулийн удирдлагын зүгээс сургуулийн хамт олныг мэдээллээр тогтмол хангах.
- Дунд болон урт хугацаанд
  - ✓ Сургуулийн хамт олны бүх гишүүд, ажилчид, сурагчид, тэр дундаа хамгийн эмзэг бүлэгт хамрагдах хүмүүсийг сүүлийн үеийн мэдээ, мэдээллээр хангах.
  - ✓ Эрсдэлд буй суралцагчидтай холбоотой байх харилцаа холбооны механизмыг бүрдүүлэх.
  - ✓ Сургуулийн үйл ажиллагаа зогссон үед боловсролын талаарх сэтгэгдлийг суралцагчид болон тэдний гэр бүлийнхнээс авах, цаашид гарч болзошгүй асуудлаарх санал хүсэлтээ илрэхийлэх боломжийг албан ёсоор олгох.

## Эх сурвалж

Асим, С. (2019 он) Малави дахь алслагдсан нийгэмлэгт багш нарыг шилжүүлэх нь: Багш нарыг нүүлгэн шилжүүлэлтийн мэдээлэлд суурилсан хандлага.

[https://inee.org/system/files/resources/TM\\_48.%20World%20Bank%20Moving%20teachers%20to%20Malawi%E2%80%99s%20remote%20communities-%20A%20data-driven%20approach%20to%20teacher%20deployment.pdf](https://inee.org/system/files/resources/TM_48.%20World%20Bank%20Moving%20teachers%20to%20Malawi%E2%80%99s%20remote%20communities-%20A%20data-driven%20approach%20to%20teacher%20deployment.pdf)

Чэйз, И., Кеннеди, И., Луриллард, Д., Абу Могли, М., Ферали, Т., Шуяаб, М. (2019 он) Олон нийтийн нүүлгэн шилжүүлэлтийн үед багшийн мэргэжлийн хөгжилд чиглэсэн хамтран боловсруулсан холимог аргачлал.

[https://inee.org/system/files/resources/TPD\\_24.%20RELIEF%20A%20Co-designed%20Blended%20Approach%20for%20Teacher%20Professional%20Development%20in%20Contexts%20of%20Mass%20Displacement.pdf](https://inee.org/system/files/resources/TPD_24.%20RELIEF%20A%20Co-designed%20Blended%20Approach%20for%20Teacher%20Professional%20Development%20in%20Contexts%20of%20Mass%20Displacement.pdf)

Коеций, А. (2019 он) Багш нарт зориулсан дасгалжуулалт, ажиглалт, эргэцүүлэлт, тэдний оролцоо: Багш нарын сайн сайхан байдал, тэдэнд дэмжлэг үзүүлэх хөндлөнгийн оролцоо.

[https://inee.org/system/files/resources/TWB\\_42.%20WCH%20Coaching%20Observing%20Reflecting%20Engaging%20CORE%29%20for%20Teachers\\_%20A%20wellbeing%20and%20support%20intervention%20for%20Teachers.pdf](https://inee.org/system/files/resources/TWB_42.%20WCH%20Coaching%20Observing%20Reflecting%20Engaging%20CORE%29%20for%20Teachers_%20A%20wellbeing%20and%20support%20intervention%20for%20Teachers.pdf)

Долан, Ж., Гоулден, А., Ндарухуца, С., Уинтроп, Р. (2012 он) Тогтворгүй, зөрчилтэй орнуудын багш нарын цалингийн үр дүнтэй тогтолцоог бий болгох.

[https://www.brookings.edu/wp-content/uploads/2016/06/09\\_CfBT\\_BrookingsReport.pdf](https://www.brookings.edu/wp-content/uploads/2016/06/09_CfBT_BrookingsReport.pdf)

Вашингтон, ДиСи: Брукингс дахь Бүх нийтийн боловсролын төв Онцгой байдлын үеийн Боловсролын агентлаг хоорондын сүлжээ (2004 он). Боловсролын хамгийн бага стандарт: Бэлэн байдал, хариу арга хэмжээ, сэргэлт.

[https://inee.org/system/files/resources/INEE\\_Minimum\\_Standards\\_Handbook\\_2010%28HSP%29\\_EN.pdf](https://inee.org/system/files/resources/INEE_Minimum_Standards_Handbook_2010%28HSP%29_EN.pdf)

Лоди, К., (2019 он) “Дэмжигчдийг дэмжих нь”: Удаан хугацааны зөрчилдөөнд амьдарч буй багш болон дурвэгч багш нар

[https://inee.org/system/files/resources/TWB\\_37.%20NRC%20Supporting%20the%20Supporters%20.pdf](https://inee.org/system/files/resources/TWB_37.%20NRC%20Supporting%20the%20Supporters%20.pdf)

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (2020 он) Зааж сургах, суралцахуйн олон улсын судалгааны 2018 оны үр дүн (II боть): Багш, сургуулийн удирдлагуудыг үнэ цэнтэй мэргэжилтэн хэмээн үзэх нь.

<http://www.oecd.org/education/talis-2018-results-volume-ii-19cf08df-en.htm>

Сайд, А., Каспер, Ж. (2019 он) Тавасол: Египет дэх Сирийн албан бус сургалтын салбарын Сири, Египетийн багш нарын өргөтгөсөн, онлайн мэргэжлийн хөгжлийн туршилтын төсөл. Хямралын нөхцөлд буй багш нар: Багшийн менежмент, мэргэжлийн хөгжил, сайн сайхан байдлын талаарх ирээдүйн практик.

[https://inee.org/system/files/resources/TiCC%20Case%20Studies%20Compilation\\_March2020\\_update.pdf](https://inee.org/system/files/resources/TiCC%20Case%20Studies%20Compilation_March2020_update.pdf)

Шлайхер, А. (2020 он) КОВИД-19 цар тахлын эсрэг багш нар болон сургуулийн тогтолцооноос үзүүлэх хариу арга хэмжээ. Зааж сургах, суралцахуйн олон улсын судалгааны зарим сургамж <https://www.oecd-forum.org/users/50583-andreas-schleicher/posts/63740-how-can-teachers-and-school-systems-respond-to-the-covid-19-pandemic-some-lessons-from-talis>

<https://www.oecd-forum.org/users/50583-andreas-schleicher/posts/63740-how-can-teachers-and-school-systems-respond-to-the-covid-19-pandemic-some-lessons-from-talis>

ЮНЕСКО (2018 он). ЮНЕСКО-ийн Багш нарын МХХТ-ийн чадамжийн хүрээ. Хувилбар 3.

<https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000265721?posInSet=1&queryId=6678569f-1351-46b1-9457-2a5734f823a3>

ЮНЕСКО (2019 он). Боловсролын хяналт шинжилгээний дэлхийн тайлан 2019. Жендэрийн тайлан. Жендэрийн тэгш байдлын төлөө гүүр барих нь

<https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000368753?posInSet=1&queryId=2a794bb7-91bf-4e2f-8977-82f50b9dc857>

ЮНЕСКО (2020 он). КОВИД-19 цар тахлын эсрэг Боловсролын салбарын хариу арга хэмжээний вебинар. Сургуулийн үйл ажиллагаа зогссон үед суралцахуйн тасралтгүй байдлыг хангахад багш нарт дэмжлэг үзүүлэх нь - Синтезийн тайлан. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373248>

ЮНЕСКО (2020 он). КОВИД-19 цар тахлын эсрэг Боловсролын салбараас үзүүлэх хариу арга хэмжээ. Асуудал №7.1. Сургуулиудын үйл ажиллагааг дахин нээх нь. <https://unesdoc.unesco.org/ark:/48223/pf0000373275>



ЮНЕСКО ба Боловсролын төлөвлөлтийн олон улсын хүрээлэн Поул де Дакар (2016 он). Багшийн хуваарилалтыг илүү үр дүнтэй удирдан зохион байгуулах талаар туршлага солилцох семинар. Антерхалтер, И., Норт, А., Арнот, М., Ллойд, К., Молецэйн, Л., Мерфи-Грэм, И., Паркс, Ж.,

Саито, М. (2014 он) Охидын боловсрол, жендэрийн тэгш байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ. <http://eppi.ioe.ac.uk/cms/Default.aspx?tabid=3493>

Дэлхийн боловсролын блог (2020 он). КОВИД-19: Зайн сургалтын талаарх багш нарт зориулсан сургалт хэлэлцүүлгийг яагаад хийхгүй байна вэ? <https://gemreportunesco.wordpress.com/2020/04/01/covid-19-wheres-the-discussion-on-distance-learning-training-for-teachers/>

## ЮНЕСКО-ийн Боловсролын салбарын онцлох асуудал

ЮНЕСКО-ийн Боловсролын салбарын онцлох асуудалд КОВИД-19 цар тахлын эсрэг Боловсролын хариу арга хэмжээтэй холбогдох гол сэдвүүдийг хөндөнө. Үүнд сургууль хаагдсантай холбоотой гарсан үр нөлөөг бууруулах хүчин чармайлтын хүрээнд сайн туршлага бүхий баримт, практик зөвлөмж, агуулга тус бүрийн гол эх сурвалж, холбоосыг багтаасан.

Онцлох асуудал нь дараах үндсэн есөн агуулгын хүрээнд хэд хэдэн асуудлыг хамарна. Үүнд: Эрүүл мэнд ба сайн сайхан байдал; Суралцахуй болон багшлахуйн тасралтгүй байдал; Жендэрийн тэгш боломж ба тэгш байдал; Багшлахуй ба суралцахуй; Дээд боловсрол ба Техник мэргэжлийн боловсрол, сургалт; Боловсрол ба соёл; Боловсролын бодлого, төлөвлөлт; Эмзэг бүлгийн хүн ам; Дэлхийн иргэний боловсрол ба Тогтвортой хөгжлийн боловсрол зэрэг орно.

Эдгээр сэдвийг ЮНЕСКО-ийн боловсролын мэргэжил нэгт нөхдүүд хамтран бэлтгэсэн юм. Энд дурдсан сэдвийг ЮНЕСКО-ийн Сантьяго болон Бейрут дахь төлөөлөгчийн газрын дэмжлэгтэйгээр ЮНЕСКО-ийн Боловсролын төлөвлөлтийн олон улсын хүрээлэн, Багшийн хөгжлийн хэлтсээс боловсруулав.

## Бидэнтэй хамт байгаарай

КОВИД-19-ийн эсрэг ЮНЕСКО-ийн Боловсролын салбарын хариу арга хэмжээ



[COVID19taskforce@unesco.org](mailto:COVID19taskforce@unesco.org)



<https://en.unesco.org/covid19/educationresponse>



@UNESCO



@UNESCO